



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/807

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Т.Лхагвадорж (ГЮ68081419)-ийн Булган сумын 6 дугаар багийн Залуус 2 дугаар гудамжны 211 тоот хаягт байршилтай, 6308002774 нэгж талбарын дугаартай, амины орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 600 м² газрын газар эзэмших эрхийг иргэн Д.Мягмардорж (ГЮ84101511)-д 15 жилийн хугацаатай, иргэн Н.Отгонжаргал (ГЮ80042465)-ын Булган сумын 6 дугаар багийн Залуус 13 дугаар гудамжны 13116 тоот хаягт байршилтай, 6308007663 нэгж талбарын дугаартай, амины орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 600 м² газрын газар эзэмших эрхийг иргэн Б.Цогбадрах (Ц387031018)-д 6 жилийн хугацаатай тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Д.Мягмардорж, Б.Цогбадрах нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээ олгон, газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2006 оны 128 дугаар захирамжийн иргэн Т.Лхагвадоржтой, мөн аймгийн Засаг даргын 2024 оны А/711 дүгээр захирамжийн иргэн Н.Отгонжаргалтай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР